



МОНГОЛ УЛСЫН УНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО



МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД БОЛОН ЯДУУРЛЫН ЗУРАГЛААЛ-2011

БҮС, АЙМАГ, СУМ, ДҮҮРГИЙН ТҮВШНИЙ ҮР ДҮН

Харолд Коуломб
Алтанхуягийн Гэрэлтуяа

2012 он

**МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД
БОЛОН ЯДУУРЛЫН ЗУРАГЛААЛ-2011**
БҮС, АЙМАГ, СУМ, ДҮҮРГИЙН ТҮВШНИЙ ҮР ДҮН

Үндэсний Статистикийн Хороо
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Ядуурал, Мянганы
хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний
тогтолцоог дэмжих” төсөл

Эдийн Засгийн Хөгжлийн Яам 124 тоот
Улаанбаатар-15015
Нэгдсэн Үндэсний Байгууллагын гудамж 5/1
Чингэлтэй дүүрэг, Монгол улс
Утас/Факс: (976-51) 261571

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧ ХУРААНГУЙ	5
УДИРТГАЛ.....	6
 I. ЯДУУРЛЫН ЗУРАГЛАЛЫН АРГАЧЛАЛ.....	7
Мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүд.....	7
Мөнгөн дүнгээр үл хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүд.....	7
 II. ҮР ДҮН	8
Мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүд.....	8
Мөнгөн дүнгээр үл хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүд.....	12
Ядуурлын үзүүлэлтүүдийн хоорондын холбоо.....	15
 III. ДҮГНЭЛТ.....	16
 АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	17
 ХАВСРАЛТ 1: Мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох аргачлал.....	18
ХАВСРАЛТ 2: Мэдээллийн сан, Монгол Улсын засаг захиргааны нэгж.....	20
ХАВСРАЛТ 3: Мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтийг тооцох аргачлалыг хэрэглэх нь.....	22
ХАВСРАЛТ 4: Судалгааны мэдээллийн регрессийн загварууд.....	26
ХАВСРАЛТ 5: Засаг захиргааны нэгж	29
ХАВСРАЛТ 6: Засаг захиргааны нэгжийн түвшинд тооцсон ядуурлын болон бусад үзүүлэлтээр хийсэн газрын зургууд.....	34
ХАВСРАЛТ 7: Ядуурлын үзүүлэлтүүдийн корреляцийн матриц.....	92
ХАВСРАЛТ 8: Ядуурлын үзүүлэлтүүд, бүс, аймаг, сум, дүүргээр.....	93
ХАВСРАЛТ 9: Хүн амын түвшинд тооцсон бусад үзүүлэлтүүд, бүс, аймаг, сум, дүүргээр..	110
ХАВСРАЛТ 10: Өрхийн түвшинд тооцсон бусад үзүүлэлтүүд, бүс, аймаг, сум, дүүргээр...124	

ӨМНӨХ ҮГ

Монгол улсын хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын талаарх бодитой тоо, мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцож мэдээллийг шинэчлэх зорилгоор Үндэсний Статистикийн Хороо “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд үндэслэн жил бүр ядуурлын үзүүлэлтүүдийг улс, бүсийн түвшинд тооцож ирсэн билээ.

Зөвхөн улс, бүсийн түвшний мэдээллийг ашиглах нь зорилтолт хөтөлбөрийг зөв олж тодорхойлоход хүндрэлтэй юм. Иймээс ядуурлын үзүүлэлтүүдийг аймаг, сум, дүүргийн түвшинд тооцох шаардлагын дагуу Үндэсний статистикийн хороо ядуурлын газрын зураглал байгуулах, Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдийг тооцох чиглэлээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран ажиллаж ирсэн бөгөөд ядуурлын зураглалын анхны тооцоог Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, Амьжиргааны түвшний судалгааны 2002/03 оны тоо мэдээллийг ашиглан 2009 онд туршилтын журмаар хийж тайлан гаргасан. Энэ удаад Монгол улсын Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны судалгааны тоо мэдээллийг ашиглан ядуурлын үзүүлэлтүүдийг засаг захиргааны хамгийн боломжит анхан шатны нэгжээр тооцсон хоёр дахь тайланг эрхэм хэрэглэгч Та бүхэнд толилуулж байна.

Манай улсын хувьд нийслэл хот, аймгийн төв, сумын төв, хөдөө дэх ядуурлын байдал ихээхэн ялгаатай учир энэхүү ядуурлын зураглал нь засаг захиргааны анхан шатны нэгж дэх хүн амын амьжиргааны байдлыг харуулах чухал мэдээлэл болно. Энэхүү тайлан нь ядуурлыг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдийн явцад үнэлэлт өгөх, хэрэгжилтийг цаашид эрчимжүүлэх талаар төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч наарт хэрэгцээтэй гарын авлага болно гэдэгт итгэлтэй байна.

Мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээг олон улсын нийтлэг арга зүйн дагуу чанартай гүйцэтгэж, үр дүнгийн тайланг бичсэн олон улсын зөвлөх Харолд Коуломб, дотоодын зөвлөх А.Гэрэлтуяа наарт талархал илэрхийлье. Түүнчлэн төслийг хэрэгжүүлэхэд хичээл зүтгэл гарган ажилласан НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Сезин Синаноглу, ажилтан Ж.Должинсүрэн, П.Цэцэгээ, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Ядуурал, мянганы хөгжлийн зорилтуудын хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих” төслийн үндэсний менежер Д.Оюунбадам, захиргаа, санхүүгийн ажилтан Б.Түвшинбилэг болон мэдээлэл боловсруулахад мэргэжлийн туслалцаа үзүүлж хамтран ажилласан YCX-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах шинжээч С.Болормаа, шинжээч Д.Даваажаргал, Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын ахлах шинжээч З.Нансалмаа, С.Лхагвасүрэн наарт талархал илэрхийлье.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА



С.МЭНДСАЙХАН

ТОВЧ ХУРААНГҮЙ

Энэхүү тайланд Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны судалгааны мэдээллийг үндэслэн хийсэн ядуурлын зураглалын үр дүнг танилцуулж байна.

Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдтэй нягт уялдаа бүхий ядуурлыг хэмжих бусад үзүүлэлтүүдийг хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийн санг үндэслэн тооцож газрын зураглал гаргалаа. Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийн санд хүн амын орлого, түүний зарцуулалттай холбоотой тоо мэдээ ороогүй байгаа учир ядуурлын үзүүлэлтүүдийг ганцхан тооллогын мэдээллийн сангаас тооцох боломжгүй байсан юм.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг статистикийн аргаар нэгтгэн тооцож, ядуурлын хамралтын хүрээ болон бусад үзүүлэлтүүдийг засаг захиргааны нэгжийн түвшинд тооцсон болно. Тооцооны үр дүнгээс харахад хоёр гол дүгнэлт гарч байна. Нэгдүгээрт, тооцсон үзүүлэлтүүдийн дийлэнх нь аймаг, сум, дүүргийн түвшинд нилээд ялгаатай харагдаж байна. Ядуурлын энэхүү ялгаа нь ядуурлын болоод бусад үзүүлэлтүүдийн аль алинд нь зорилтот бүлгийг газар зүйн байршилаар тодорхойлоход чухал ач холбогдолтой болохыг харуулж байна. Хоёрдугаарт, янз бүрийн үзүүлэлтүүд хоорондын корреляцийн хамаарал ихэнх тохиолдолд нилээд сул байна. Иймд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад хөтөлбөр, төсөл бүрт тохирсон онцлог үзүүлэлтүүдийг боловсруулж байх шаардлага гарч байна. Мэдээж хэрэг хязгаарлагдмал, цөөхөн үзүүлэлт бүхий мэдээлтэй байх нь аливаа хөтөлбөр, төслийн үр ашгийг тооцоход хязгаарлагдмал байх болно.

УДИРТГАЛ

Энэхүү тайландаа Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны судалгааны мэдээллийг ашиглан хийсэн ядуурлын зураглалын тооцоо, үр дүнг танилцуулах болно. Ингэхдээ Элбэр, Ланжоу нарын боловсруулсан аргачлалыг ашиглан ядуурлын үзүүлэлтүүдийг засаг захиргааны боломжит анхан шатны нэгжийн түвшинд тооцоходоо судалгаанд орсон нарийвчилсан үзүүлэлтүүдийг тооллогод хамрагдсан хүн амын тоо мэдээлэлд тулгуурлан аль болох нарийвчлан тархааж тооцох аргыг ашигласан. Үр дүнг таван бүс, 22 аймаг, 329 сум, 9 дүүргийн түвшингээр гаргалаа.

Сүүлийн арван жилд ядуурлын дүр төрхийг¹ ядуурлын үзүүлэлтүүдийг тодорхойлох, үнэлэх, хянах олон арга хэрэгслийдээр тодорхойлж ирсэн. Өрхийн судалгаагаар цуглуулсан өрхийн орлого, зарлагын талаарх нарийвчилсан тоо мэдээллийг үндэслэн хүн амын амьжиргааны түвшний шинж байдлыг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр илэрхийлэгдэх үзүүлэлтүүдээр тодорхойлж ирсэн нь ядуурлыг бууруулахад чиглэсэн зарим бодлого хөтөлбөрийг үнэлэхэд дэм болж, ядуурлын түвшинг бүс нутгуудын хүн амын бүлгүүдийн түвшинд гаргаж, зэрэгцүүлэлт харьцуулалт хийхэд ашиглагдаж байна. Өрхөд суурин сэргээр тооцооллын ажлын үр дун нь хүн амын аж байдлыг өрхийн түвшинд ерөнхийд нь харуулах, түүнчлэн ядуу хэсгийн талаар зарим мэдээллийг олж мэдэхэд тустай ч зарим сул талтай байна.

Ялангуяа, ядуурлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шийдвэр гаргагчид, төлөвлөгчдөд нилээд нарийвчилсан мэдээлэл шаардлагатай байдаг. Тэдэнд хүн амын суурьшлаарх мэдээлэл, тухайлбал, хөрш зэргэлдээ газрууд, аймаг, хот, суурин тосгоны түвшинд тооцсон мэдээлэл чухал юм. Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид тусламж дэмжлэг шаардлагатай хэсэг хөдөөд илүү байна гэж үздэг нь хэтэрхий тойм мэдээлэл бөгөөд тэдэнд аль аймаг тэр тусмаа аль суманд ядуурал их байгааг тодорхой мэдээлэх нь үр дүнтэй, илүү ач холбогдолтой юм.

Бүсийн түвшний мэдээлэл ашиглах нь ядуурлыг бууруулах зорилтот хөтөлбөрийг оновчтой тодорхойлоход учир дутагдалтай, ядуурал харьцангуй бага засаг захиргааны нэгж зорилтот хөтөлбөрүүдэд хамрагдах нэхцлийг бий болгоно. Суурьшлын аль болох доод түвшингээр тооцсон нарийвчилсан мэдээлэлтэй болсноор үргүй зардлыг багасгаж, ядуурлыг бууруулах хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэх нэхцөлийг бүрдүүлнэ. Тухайн бүсийн тэгш бус байдлыг тодорхойлоход суурьшлын аль болох доод түвшингээр тооцсон ядуурлын үзүүлэлтүүд чухал юм.

Өрхийн зарлагын мэдээлэлд үндэслэн ядуурлын үзүүлэлтүүд тооцсон аргачлал нь ядуурлын дүр төрхийг тодорхойлсон аргачлалтай бүрэн тохирч байгаа төдийгүй ядуурлын бүх үзүүлэлтүүдийн стандарт алдааг тооцох боломжийг олгож байгаа юм. Энэ аргачлалаар тооцсон тооцоо нь бүсийн түвшинд тооцсон ядуурлын түвшний тооцоотой яв цав таарч байх ёстой бөгөөд ядуурлын түвшний мэдээллийг суурьшлын хувьд илүү нарийвчилж байгаа юм.

Энэ тайландаа ядуурлын үзүүлэлтүүдээс гадна мөнгөн дүнгээр үл хэмжигдэх үзүүлэлтүүдийг оруулсан бөгөөд тэдгээрийн олонхи нь Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлтүүд байна. Тооллогын мэдээллийн баазаас мөнгөн дүнгээр үл хэмжигдэх 28 үзүүлэлтийг ядуурлын үзүүлэлтүүд тооцсонтой ижил суурьшил /бүс, аймаг, сум, дүүрэг/-аар тооцлоо.

Энэхүү тайлангийн 1-р хэсэгт мөнгөн дүнгээр хэмжигдэх болон мөнгөн дүнгээр үл хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүдийг тооцсон аргачлалыг энгийн хэллэгээр тайлбарласан бөгөөд 2-р хэсэгт тооцооны үндсэн үр дүнг оруулав. 3-р хэсэгт үр дүнг бодлого, хөтөлбөрт хэрхэн ашиглаж болох

¹ YCX (2012)-ны Монгол Улсын ядуурлын дүр төрх тайлан.

талаарх зөвлөмж бүхий дүгнэлт орууллаа. Аргачлалын техникийн тайлбарууд, уг аргачлалыг практикт хэрхэн ашиглах талаарх мэдээллийг Хавсралт 1-4-т оруулав. Үндсэн үр дүнг газрын зураг (Хавсралт 5-6), хүснэгт (Хавсралт 8-10) гэсэн хоёр хэлбэрээр үзүүлсэн болно. Хавсралт 7-д үзүүлэлтүүдийн хамаарал (корреляци)-ын матрицыг үзүүллээ.

I. ЯДУУРЛЫН ЗУРАГЛАЛЫН АРГАЧЛАЛ

Энэхүү тайланда орж байгаа үзүүлэлтүүдийг тооцоходо мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүд тооцох, мөнгөн дүнгээр үл хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүд тооцох гэсэн хоёр аргыг ашигласан.

МӨНГӨН ДҮНГЭЭР ХЭМЖИГДЭХ ЯДУУРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аргачлал нь ерөнхийдөө маш энгийн. Эхлээд өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг ашиглан нэг хүнд ногдох зарлагын регрессийн загвар гаргаж, тооллого болон судалгааны мэдээлэлд аль алинд нь байгаа ижил төрлийн үзүүлэлтүүдээ ялгаж багцална. Дараа нь энэ загвараар тооцсон коэффициентуудаар хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг ашиглан тооллогод хамрагдсан өрх бүрийн зарлагыг тооцно. Эцэст нь ингэж тооцсон өрхийн зарлагын мэдээллээ ашиглан хүн амын аж байдлын үзүүлэлтүүдийг (ядуурлын хамралтын хүрээ, гүнзгийрэлт, мэдрэмж, тэгш бус байдал²) газарзүйн өөр өөр байршилаар тооцно.

Энэхүү аргачлал нь ойлголтын хувьд хялбар мэт боловч тооцооны хувьд маш нарийн төвөгтэй тооцоопол шаарддаг. Ийм төвөгтэй байдал нь орон зайн автокорреляци (нэг нутаг дэвсгэрт оршин суугаа өрхүүдийн хэрэглээ өөр хоорондоо харилцан хамааралтай байх) болон гетероскедастик (хэрэглэж байгаа загварын тооцооллын дотоод уялдаа)-г засварлах үед голчлон үүсдэг. Эконометрикийн эдгээр нөхцөлийг харгалзан үзсэнээр регрессийн шинжилгээн дэх үнэлгээнүүд хазайлтгүй, тооцоо зөв байх нөхцөлийг бүрдүүлнэ. Тооцооны алдааг багасгах үүднээс хүн амын аж байдлын үзүүлэлт бүрийн стандарт алдааг тооцох шаардлага гардаг. Эдгээр стандарт алдаа нь бидэнд ядуурлын үзүүлэлтүүдийг засаг захирагааны нэгжийн хэр доод түвшинд тооцож болохыг тодорхойлж өгдөг. Тооцоог засаг захирагааны нэгжийн түвшингээр задлах тусам эконометрикийн загварт хамрагдах өрхийн тоо цөөрч улмаар тооцооны нарийвчлал буурна. Засаг захирагааны тодорхой нэг түвшинд ядуурлын үзүүлэлтүүдийн тооцооны нарийвчлал илүү ихээр алдагдаж байсан. Иймээс дээр дурьдсан стандарт алдаа нь ядуурлын үзүүлэлтүүдийн тооцоог засаг захирагааны нэгжийн аль түвшинд тооцохыг тодорхойлж өгсөн. Энэ аргачлалын талаар нилээд дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс, тоо мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү. Харин Хавсралт 3,4-т мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүдийн үр дүнг дэлгэрэнгүй үзүүлсэн болно.

МӨНГӨН ДҮНГЭЭР ҮЛ ХЭМЖИГДЭХ ЯДУУРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөнгөн дүнгээр үл хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүд нь тооцоход хялбар, давхар тооцоопол шаарддаггүй. Ихэнх тохиолдолд эзлэх хувийн жинг ашигладаг, тухайлбал, цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын хувийн жин гэх мэт.

² Орон нутгийн түвшинд тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг тооцсон хэдий ч энэ тайланда тусгаагүй. Тэгш бус байдлыг орон нутгийн түвшинд тооцох нь төвөгтэй бөгөөд тайлбар хийхэд хүндрэлтэй. Шаардлагатай гэж үзвэл судалгаа, шинжилгээний зорилгоор тооцоог гаргах боломжтой.

II. ҮР ДҮН

Энэ хэсэгт мөнгөн дүнгээр хэмжигддэг болон мөнгөн дүнгээр үл хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүдийн тооцооны үр дүнг оруулсан болно.

МӨНГӨН ДҮНГЭЭР ХЭМЖИГДЭХ ЯДУУРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх хэсэг болон Хавсралт 1-4-т байгаа аргачлалын дагуу мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүдийг бүс, аймаг, сум, дүүргээр тооцсон болно. Үр дүнг Хавсралт 8-аас харах боломжтой. Эдгээр хүснэгтэд ядуурлын үндсэн үзүүлэлтүүд болох ядуурлын хамралтын хүрээ, гүнзгийрэлт, мэдрэмжийн³ индексүүдийг тооцсон болно. Эдгээрээс гадна хүн амын тоо, ядуу хүмүүсийн тоог засаг захиргааны нэгж (аймаг, сум, дүүрэг)-ээр, аймаг, сум, дүүргийн түвшин дэх ядуурлын үзүүлэлтүүдийг газрын зургаар харуулсан болно. Ядуурлын хамралтын хүрээг газрын зураг 1а-1в, ядуурлын гүнзгийрэлтийг Хавсралт-6-гийн газрын зураг 2а-2в-д харууллаа. Засаг захиргааны нэгжүүдийн хил хязгаарыг тодорхой харуулахын тулд Хавсралт 5-д бүс, нийслэл, аймаг, дүүрэг, сумын нэр бүхий газрын зургийг харуулсан болно.


Ядуурлын түвшинг газрын зургаар харуулах нь хүснэгтээр харуулснаас илүү ойлгомжтой байдаг. Газрын зураг 1а-1в-ээс харахад ядуурлын хамралтын хүрээ засаг захиргааны нэгжээр задрах тутам өвөрмөц дүр төрх ажиглагдаж байна. Эдгээр зургаас таван бүсийн ядуурлын хамралтын хүрээ хэр ялгаатай байгаа нь илүү тодорхой харагдаж байна. Тухайлбал, бүсийн түвшинд ядуурлын голч бүс болох Баруун бүсэд ядуурал хамгийн багатай (Увс), хамгийн ихтэй (Говь-Алтай) аймгууд мөн улсын хэмжээнд хоёр дахь ядуурал ихтэй сум болох Эрдэнэ сум багтаж байна. Эндээс ядуурлын зураглал хэр ач холбогдолтой болох нь тодорхой харагдаж байна. Ядуурлын гүнзгийрэлтийн газрын зургууд мөн дээрхтэй ижил дүр төрхийг илэрхийлж байгаа юм.

Зураг 1а-д бүс нутгийн доторхи ядуурлын түвшингийн ялгааг статистикийн аргаар үзүүллээ. Зураг дээрх босоо шугам нь бүсийн доторх ядуурлын хамралтын хүрээний ялгааг харуулж байна. Үүнийг аймгаар задалж үзэхэд, бүс доторх ядуурлын түвшингийн ялгаа гурван бүсэд хамгийн их (Баруун, Төв, Хангай) ялгаатай, хоёр бүсэд (Улаанбаатар, Зүүн) хамгийн бага байгаа нь харагдаж байна. Зураг 1б нь сумын түвшинд дээрхтэй ижил дүр зургийг харуулж байна. Эдгээр зургуудыг харахад, бүс доторх сумдын ялгаа нь Улаанбаатар хот болон Зүүн бүсэд илүү өөрчлөлттэй байна. Ядуурал ихтэй аймаг, сумдад чиглэсэн ядуурлыг бууруулах хөтөлбөр боловсруулахад шаардлагатай чухал мэдээллийг ядуурлын зураглалаас харж болно.

³ Эдгээр гурван индексүүд нь Фостерийн тооцоолсон индексүүдийн хэсэг болно (1984).


ГАЗРЫН ЗУРАГ 1: ЯДУУРЛЫН ХАМРАЛТЫН ХҮРЭЭ (РО)

А) Бүс




Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээлэлд үндэслэн судлаачдын хийсэн тооцоо

Б) Аймаг



Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээлэлд үндэслэн судлаачдын хийсэн тооцоо


В) Сүм



Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээлэлд үндэслэн судлаачдын хийсэн тооцоо

**ЗУРАГ 1: ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ТООЦСОН ЯДУУРЛЫН
ХАМРАЛТЫН ХҮРЭЭНИЙ ХЭЛБЭЛЗЭЛ, БҮСЭЭР**


А) Аймаг



Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны судалгааны мэдээллийг үндэслэн судлаачдын хийсэн тооцоо

Тэмдэглэл: Хар цэг (●) нь бүсийн түвшний ядуурлын хамралтын хүрээ, босоо татсан зураас (l) нь тухайн бүс дэх аймгуудын ядуурлын хамралтын хүрээний хэлбэлзэл

Б) Сум



Тэмдэглэл: Хар цэг (●) нь бүсийн түвшний ядуурлын хамралтын хүрээ, босоо татсан зураас (l) нь тухайн бүс дэх сумдын ядуурлын хамралтын хүрээний хэлбэлзэл

МОНГӨН ДҮНГЭЭР ҮЛ ХЭМЖИГДЭХ ЯДУУРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мянганы хөгжлийн есөн зорилт (МХЗ)-ын хэрэгжилтийг дал орчим үзүүлэлтээр үнэлж байна. Монгол Улсын хувьд эдгээр үзүүлэлтүүдийн дийлэнхийг үндэсний түвшинд тооцож байна. МХЗ-ын хэрэгжилтийн чиг хандлагыг үнэлэхэд гол үзүүлэлтүүдийг үндэсний түвшинд тооцох нь чухал хэдий ч бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад засаг захиргааны нэгжээр задалсан тооцоо мэдээлэл хэрэгтэй байдаг. Засаг захиргааны нэгжээр тооцсон МХЗ-ын үзүүлэлтүүд нь батлагдсан төсвийн хүрээнд зорилтот бүлгээ оновчтой тогтоох, байгаа нөөцөө үр ашигтай зарцуулан ядуурлыг бууруулахад тус нэмэр болно. Гэхдээ зарим үзүүлэлтүүдийг үндэсний түвшинд тооцох шаардлагатайг бодолцох ёстой. Тухайлбал, Улсын Их Хурлын нийт гишүүдийн тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь гэх мэт. МХЗ-ын эхний хоёр үзүүлэлт (ядуурлын хамралтын хүрээ, гүнзгийрэлт)-ийг дээр танилцуулсан тул энэ хэсэгт мөнгөн дүнгээр үл хэмжигдэх 28 үзүүлэлтийг хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээлэлд үндэслэн бүс, аймаг, сум, дүүргээр тооцлоо. МХЗ-ын зарим үзүүлэлтүүдийг тооцоход одоо мөрдөж байгаа албан ёсны тодорхойлолтыг ашиглаагүй хэдий ч тооцсон үзүүлэлтүүд нь маш чухал мэдээлэл болж байгаа юм. Ядуурал нь олон хэмжээст үзэгдэл хэдий ч эдгээр 28 үзүүлэлт нь мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүдэд нэмэлт чухал мэдээлэл болсон гэж үзэж байна.

Хүснэгт 1-д дээрх 28 үзүүлэлтийг дэлгэрэнгүйгээр үндэсний түвшинд, боломжтойг нь хүйсээр задлан харуулсан болно. Бүс нутаг, аймаг, сумд, дүүргийн үзүүлэлтийг Хавсралт 9, 10-т, харуулав. Түүнчлэн эдгээр үзүүлэлтүүдийг газрын зургаар Хавсралт 6-д үзүүлэв. Үзүүлэлт бүрийг бүс, аймаг, сум, дүүргээр задалж харуулахыг зорьсон болно. Хүснэгт 1-ийн эхний багананд үзүүлэлт бүрийн дэс дугаарыг үзүүлсэн бөгөөд ашиглахад хялбар байлгах үүднээс газрын зургийг ч мөн энэ дугаараар дугаарласан болно. Үзүүлэлт бүр ядуурлын хамралтын хүрээтэй хамааралтай эсэхийг Хавсралт 6-ын Зураг 4-31-т үзүүлсэн болно.

Бичиг үсэг тайлгадалтын түвшингээс бусад бүх үзүүлэлтүүд засаг захиргааны нэгжийн түвшинд их ялгаатай байна. Энэ ялгаатай байдал нь зорилтот бүлгийг тодорхойлоход нэмэлт чухал үзүүлэлт байж болох юм.

Газрын зураг 3-т 15-59 насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин засаг захиргааны нэгжээр (аймаг, сум, дүүрэг) тооцсоноос харахад сумын түвшний үзүүлэлтүүд илүү анхаарал татаж байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 50-иас 90 хувь хүртэл хэлбэлзэж байгаа бөгөөд Монголын баруун, зүүн хязгаарын болон хойд хэсгийн сумдад бага, харин төв, өмнө хэсгийн сумдад өндөр байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин мөн дээрхтэй ижил хандлагатай байна ([4], Газрын зураг 4).

Улсын хэмжээний нийт ажиллагчдын 45 орчим хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байгаа бөгөөд (Хүснэгт 1) энэ үзүүлэлтийг сумдаар авч үзвэл ялгаа их байна. Газрын зураг 5в-гээс үзэхэд хөдөөгийн сумдад энэ үзүүлэлт өндөр буюу бараг 100 хувь байхад хот сууринд, ялангуяа Улаанбаатар хотод бага байна. Энэ дүр зураг Хангайн бүсийн аймгуудын сумдад илүү ажиглагдаж байна.

25-59 насны хүн амын ажилгүйдлийн түвшин (үзүүлэлт [7]) 13,4 хувь байхад 15-24 насны залуучуудынх (үзүүлэлт [6]) үүнээс хоёр дахин өндөр буюу 27,1 хувь байна. Газрын зураг 6, 7-гоос харахад ажилгүйдлийн түвшин дээрх хоёр бүлэгт ижил тархалттай байгаа боловч Ховд аймгийн өмнөд хэсгийн, Дорнод аймгийн хойт хэсгийн сумд, Улаанбаатар хот ба улсын хойт хилийн хооронд оршиж буй сумдад илүү өндөр байна.

Хүн ам зүйн ачаалал нь 18-аас доош, 64-өөс дээш насны хүн амын хувийн жингээр

тодорхойлогддог бөгөөд энэ үзүүлэлт өндөр байвал өрхүүдийн хөдөлмөрийн насны хүн амд илүү хүнд тусч тухайн өрх ядууралд өртөх эрсдэлийг бий болгодог. Газрын зураг 8-аас харахад хүн ам зүйн ачаалал баруун аймгуудад (Баян-Өлгий, Ховд, Увс) хамгийн өндөр, Улаанбаатар хот, түүнийг тойрсон сумдад бага байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын асуулгад орсон боловсролын асуултуудаас стандарт тодорхойлолтуудыг ашиглан сургуульд хамрагдалтын цэвэр болон бохир коэффициентуудыг тооцох боломжгүй байв. Гэхдээ сургуульд хамрагдалтын коэффициентийг сургуулийн насны хүн амын дөрвөн насны бүлгээр (6-9, 10-14, 15-19, 20-29) тооцсон болно. 6-14 насны хүүхдүүд сургуульд бараг бүрэн хамрагдаж байхад 15-19 насны хүүхдийн 80 хувь, 20-29 насны хүн амын 16 хувь нь хамрагдаж байна. Бага насны хүүхдүүд бараг бүгд сургуульд хамрагдаж байгаа ч Баян-Өлгий аймагт хамрагдалтын хувь 80 орчим байна. Зарим сумдад 10-14 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалт бага байгаа хэдий ч газар зүйн байршлын хувьд бараг ялгаагүй байна. Гэхдээ 15-аас дээш насны хүн амын сургуульд хамрагдалт өөр дүр зурагтай байна. Сумын түвшинд 15-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалт 30-100 хувь байгаа бөгөөд Дорнод аймгийн сумдад энэ үзүүлэлт хамгийн бага байна. Харин Улаанбаатар хотод сургуульд хамрагдалтын түвшинд өндөр байгаа нь ерөнхий боловсролын ахлах сургуулиуд, дээд боловсролын сургуулиуд илүү төвлөрсөн байдагтай холбоотой юм.

Монгол улсын нийслэлд бараг бүх иргэд бичиг үсэгт тайлгадсан боловч зүүн бүсийн зарим сумдад бичиг үсэг тайлгадалтын түвшин доогуур байгаа бөгөөд энэ нь хүйсийн ялгаагүй байна. (Газрын зураг 13,14-ыг үзнэ үү).

Дээрх дөрвөн насны бүлгээр сургуульд хамрагдалтын хүйсийн тэгш бус байдлыг харуулах зорилгоор сургуульд суралцаж байгаа охид, хөвгүүдийн харьцааг тооцлоо. Азийн зарим орнуудтай харьцуулахад 15-аас дээш насны охидын сургуульд хамрагдалт харьцангуй өндөр байна (Хүснэгт 1-ийг харна уу). Энэхүү харьцаа нь аймаг, сумдын түвшинд ялгаатай байгаа хэдий ч газар зүйн байршилаар ялгаа ажиглагдахгүй байна. Хүйсийн тэгш бус байдлыг илэрхийлэх өөр нэг үзүүлэлт болох хөдөө аж ахуйн бус салбарт цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн хувийн жин (үзүүлэлт [19]) мөн дээрхтэй адил хандлагыг харуулж байна.

Зүүн бүсэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувийн жин харьцангуй өндөр харагдаж байна. Гэхдээ тооллогын асуулгад хөгжлийн бэрхшээлтэй эсэхээ хүмүүс өөрсдөө тодорхойлсон учир бодит байдлаас бага зэрэг зөрүүтэй байж болно (Газрын зураг 20).

Гэр нь монголчуудын уламжлалт сууц боловч ердийн галлагаа нь агаарын бохирдолд тодорхой нөлөө үзүүлдэг. Газрын зураг 21-ээс харахад Улаанбаатар хот, Баян-Өлгий аймаг, улсын хойд хил дагуух сумдаас бусад аймаг, сумдын хүн амын олонх нь гэрт амьдарч байна.

Тооллогын мэдээллээс дэд бүтэц (ариун цэврийн байгууламж, эрчим хүчний хангамж, төвлөрсөн ус, гэх мэт)-ийн хүртээмжийг газар зүйн байршилаар харахад улсын дундажтай ойролцоо байна. Газрын зураг 22-28-аас харахад Улаанбаатар хотоос зүүн өмнөд хэсэгт орших сумдад дэд бүтцийн хүртээмж арай өндөр байхад бусад бүх газруудад дэд бүтцийн хөгжил сүл байна.

Холбоо харилцааны хоёр гол үзүүлэлт болох үүрэн телефон (Газрын зураг 29), интернетийн (Газрын зураг 30) хэрэглээг тооцлоо. Үүрэн телефоны хэрэглээ улсын хэмжээнд 93 хувь байгаа хэдийч Баян-Өлгий аймаг, бүр нарийвчилбал Баян-Өлгий аймгийн Булган суманд хамгийн бага байна. Интернетийн хэрэглээ Улаанбаатар хотод бусад бүх газруудаас өндөр байна.

Зураг 4-31-д ядуурлын мөнгөн дүнгээр үл хэмжигдэх үзүүлэлтүүд ядуурлын хамралтын

хүрээний үзүүлэлттэй хэрхэн хамааралтай болохыг сумын түвшинд тооцож үзэхэд ихэнх тохиолдолд корреляцийн коэффициент нь маш бага эсвэл тэгтэй тэнцүү байлаа. Энэ нь бидний таамаглаж байсантай ойролцоо үр дүн гарсан юм. Тухайлбал, сумдад гэрт амьдардаг хүний хувийн жин өсөх тусам ядуурлын түвшин нэмэгдэж байсан. Нөгөө талаас, арай чинээлэг сумдад интернетийн хэрэглээ, эрчим хүчний хангамж, сургуульд хамрагдалтын түвшин илүү өндөр байна.

Хүснэгт 1: Мөнгөн дүнгээр үл хэмжигдэх үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Улсын дундаж		
		Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
3	15-59 насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар	67.1	56.0	61.4
4	15-59 насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар	55.6	47.8	51.6
5	15-59 насны хүн амын хувиараа хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар	48.7	40.7	44.9
6	15-24 насны хүн амын ажилгүйдлийн түвшин, хувиар	26.8	27.5	27.1
7	25-59 насны хүн амын ажилгүйдлийн түвшин, хувиар	14.8	11.9	13.4
8	18-аас доош, 64-өөс дээш насны хүн амын хувийн жин, хувиар	т/б	т/б/б	38.3
9	6-9 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хувиар	97.0	97.6	97.3
10	10-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хувиар	96.0	97.7	96.8
11	15-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хувиар	75.3	83.6	79.3
12	20-29 насны залуучуудын сургуульд хамрагдалт, хувиар	14.3	17.3	15.8
13	Бичиг үсгийн мэдлэгтэй 15-24 насны эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	т/б	т/б/б	97.9
14	Бичиг үсгийн мэдлэгтэй 15-24 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	т/б	т/б	98.7
15	Сургуульд сурч байгаа 6-9 насны охид, хөвгүүдийн харьцаа	т/б	т/б	0.97
16	Сургуульд сурч байгаа 10-14 насны охид, хөвгүүдийн харьцаа	т/б	т/б	0.99
17	Сургуульд сурч байгаа 15-19 насны охид, хөвгүүдийн харьцаа	т/б	т/б	1.08
18	Сургуульд сурч байгаа 20-29 насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн харьцаа	т/б	т/б	1.31
19	Хөдөө аж ахуйн бус салбарт цалинтай ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	т/б	т/б	51.7
20	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувийн жин	4.6	3.7	4.1
21	Гэрт амьдардаг хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	44.9
22	Ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	22.5
23	Төвлөрсөн усан хангамжаар хангагдсан хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	36.3
24	Эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	97.2
25	Төвлөрсөн халаалтын системээр хангагдсан хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	26.7
26	Хатуу хог хаягдал зайлуулах үйлчилгээнд хамрагдсан хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	81.3
27	Дэд бүтцээр бүрэн хангагдсан хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	23.8
28	Хоол ундаа хийхдээ ихэвчлэн цахилгаан эрчим хүч ашигладаг хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	32.6
29	Үүрэн телефон ашигладаг хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	93.8
30	Гэртээ интернеттэй хүн амын эзлэх хувийн жин	т/б	т/б	47.5

Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны судалгааны мэдээллийг үндэслэн судлаачдын хийсэн тооцоо

Тэмдэглэл: т/б – тооцох боломжгүй

ЯДУУРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБОО

Засаг захиргааны анхан шатны нэгжид мөнгөн дүнгээр хэмжигдсэн ядуурлын үзүүлэлтүүдийн газар зүйн зураглал нь зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөр боловсруулахад чухал хэрэгсэл болдог. Гэхдээ ядуурлын мөнгөн дүнгээр хэмжигдэх үзүүлэлтүүдийг ашиглан хүн амын эрүүл мэнд, боловсролын зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах уу аль эсвэл боловсрол, дэд бүтцийн үйлчилгээ дутагдалтай байгааг харуулсан газрын зураглалыг ашиглах уу гэдгийг тодорхойлох шаардлагатай байгаа юм. Иймээс Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээллийг ашиглан ядуурлын үндсэн шалтгаан болж мэдэх мөнгөн дүнгээр үл хэмжигдэх 28 үзүүлэлтүүдийг ашиглан олон төрлийн газрын зураг гаргаж энэхүү тайлангийн гол хэсэг болгон орууллаа.

Энэ тайлангийн өмнөх хэсэгт ядуурлын хамралтын хүрээ мөнгөн дүнгээр үл хэмжигдэх бусад үзүүлэлтүүдтэй сүл хамааралтай байсныг өгүүлсэн. Иймд тайлангийн энэ хэсэгт ядуурлын бусад үзүүлэлтүүд өөр хоорондоо ямар холбоо хамааралтай байгааг шинжлэхийг зорилоо. Ядуурлын 30 гаруй үзүүлэлтийн өөр хоорондын корреляцийн хамаарлын тооцоог аймаг, сумын түвшинд хийж хавсралт 7-д сумын түвшин дэхь хамаарлыг үзүүлэв. Аймгийн түвшинд хийсэн шинжилгээний дүн сумын түвшингийнхтэй ижил хандлагатай байна.

Нарийвчлан шинжилж үзэхэд ихэнх тохиолдлуудад үзүүлэлтүүд өөр хоорондоо харилцан сүл хамааралтай байсан боловч зарим үзүүлэлтүүд өөр хоорондоо нягт хамааралтай байна. Тухайлбал, сургуульд хамрагдарт [12] нь ариун цэврийн байгууламжийн сүлжээнд холбогдсон байдал [22]-тай эерэг, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн түвшинтэй [5] сөрөг хамааралтай байна. Ерөнхийд нь авч үзвэл ядуурлын хамралтын хүрээ бусад (ажил эрхлэлт, боловсрол, дэд бүтэц гэх мэт) үзүүлэлттэй сүл хамааралтай байгаа нь зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөрийг гаргахдаа нэг биш хэдэн үзүүлэлтийг давхар сонгон судалж байж шийдвэрээ гаргах хэрэгтэйг анхааруулж байна. Тухайлбал, хүн амын ядуурлыг бууруулах, нийтийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах гэсэн үндсэн зорилго тавьж байгаа бол дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийхдээ дэд бүтцийн талаарх үзүүлэлтүүд, ядуурлын үзүүлэлтүүдийг давхар шинжилж байж шийдвэрээ гаргах хэрэгтэй гэсэн үг.

III. ДҮГНЭЛТ

Энэ хэсэгт Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны судалгааны тоо мэдээллийг үндэслэн бүс, аймаг, сум, дүүргийн түвшинд хийсэн ядуурлын зураглалын гол үр дүнг үзүүллээ. Эдгээр тооцоо нь Монгол Улсын хамгийн сүүлд гаргасан ядуурлын төрх байдлын үзүүлэлтүүдтэй нийцэж байгаа учир энэхүү газрын зургуудыг ядуурлын төрх байдлын үзүүлэлтүүдийн нарийвчилсан задаргаа, тайлбар хэмээн ойлгож болно. Ядуурлын мөнгөн дүнгээр хэмжигдэх үзүүлэлтүүдэд нэмэлт болгож мөнгөн дүнгээр үл хэмжигдэх бусад үзүүлэлтүүд болох ажил эрхлэлт, боловсрол, дэд бүтцийн үзүүлэлтүүдээр газрын зураглал гаргалаа. Тооцоонд орсон бүх үзүүлэлтийг таван бүс, 22 аймаг, 329 сум, 9 дүүргийн түвшинд гаргасан болно.

Сонирхолтой тооцоо, үр дүнгүүд гарсан хэдий ч бүрэн ашиглахгүй бол энэ судалгаа нь үр ашиггүй ажил болно. Тэгвэл хэрхэн ашиглах вэ? Эдгээр үр дүнг үндэслэн засаг захиргааны нэгжүүдийн түвшинд төсвийн хуваарилалтыг хийх журам гаргаж болох юм. Жишээлбэл, Засгийн газраас хүн амын ядуурлыг дорвитой бууруулах зорилгоор сумдад хөрөнгө хуваарилах боллоо гэж бодьё. Тэгвэл төсвийг хэрхэн хуваарилах вэ? Гэсэн асуулт гарна. Ядуурлын мөнгөн дүнгээр хэмжигдэх үзүүлэлтүүдийг үндэслэн янз бурийн журам гаргаж болно. Төсөв хуваарилалтын хамгийн “сайн” арга бол мэдээллүүдээ ашиглан төсвөө оновчтой хуваарилах явдал мөн. Ийм хуваарилалтын аргыг өмнө нь хийсэн (2009) ядуурлын зураглалын тайланд мөн тодорхой өгүүлсэн байгаа.

Мөнгөн дүнгээр үл хэмжигдэх үзүүлэлтүүдийг тус тусад нь авч ашиглах нь хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд арай амархан байдаг. Тухайлбал, хэрэв бодлого боловсруулагчид эрчим хүчний хангамжийг сайжруулах арга хэмжээг авах шаардлагатай бол эрчим хүчний хангамж дутагдалтай байгаа Ховд аймгийн Үенч сумыг зорилтот сум болгон авч үзэж болох юм.

Эдгээр газрын зураг нь өнөөгийн авч явуулж байгаа удирдлагын төвлөрлийг сааруулах бодлого, арга хэмжээнд чухал хэрэгсэл болно. Жишээлбэл, Засгийн газраас аймаг, сумдад төсөв хуваарилахдаа ядуурлын зураглалаар гарсан мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүдийг үндэслэн ялгаатай хуваарилах, цаашлаад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд мөнгөн дүнгээр үл хэмжигдэх үзүүлэлтүүдийг удирдамж болгон хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлээг орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн Ʉэрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц гэх мэтээр тодорхойлох боломжтой болох юм.

Ядуурлын зураглалыг ашиглах өөр нэг арга бол бий болж байгаа уул уурхайн томоохон хөрөнгө оруулалтуудын үр ашгийг шинжлэх явдал юм. Өмнө хийгдсэн ядуурлын анхны зураглал, одоогийн зураглал хоёрыг нийлүүлэн аймаг, сумдын өөрчлөлтийн нэгдсэн зургийг гаргаж болох юм. Уул уурхайн хөрөнгө оруулалт 2000-2010 оны хооронд боловсрол, хөдөлмөр эрхлэлт, дэд бүтцэд хэр нөлөө үзүүлж вэ гэдгийг ядуурлын үзүүлэлтүүдийн энэ хугацааны турш дахь динамик өөрчлөлтийг тооцож харж болно. Ийм төрлийн шинжилгээгээр хүн амын амьжиргааны түвшинд зуд хэрхэн нөлөөлснийг харж болно.

Ядуурлын зураглалыг өөр олон янзаар ашиглаж болох бөгөөд үүний нэг жишээ бол ядуурлыг бууруулах зорилтот хөтөлбөрүүдийн (төрөл бурийн сангуд, хөтөлбөрүүд) үр дүн, нөлөөллийг үнэлж болно. Мөн ядуурлын зураглалын мэдээллийг судлаачид ядуурал, нийгэм- эдийн засгийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн уялдаа холбоог судлах гэх мэт олон зорилгоор ашиглаж болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Coulombe, H. And Q. Wodon, 2007, Combining census and household survey data for better targeting: The West and Central Africa Poverty Mapping Initiative, Findings Africa Region No. 280, The World Bank, Washington, D.C.

Coulombe, Harold, 2009, Millennium Development Goals and Geographical Targeting in Mongolia, Ulan Bator: UNDP

Elbers, Chris, Jean Olson Lanjouw, and Peter Lanjouw, 2003, "Micro-Level Estimation of Poverty and Inequality" *Econometrica*, 71(1), 355-364

Foster, J.E., J. Greer and E. Thorbecke, 1984, A Class of Decomposable Poverty Measures, *Econometrica* 52: 761-766

National Statistical Office (NSO) 2012, Household Socio-Economic Survey 2011, Ulaanbaatar

Mistiaen, Johan, Berk Ozler, Tiaray Razafimanantena and Jean Razafindravonona, 2002, Putting Welfare on the Map in Madagascar, Africa Region Working Paper Series, Number 34, The World Bank. Washington, D.C.

Zhao, Qinghua, 2005, User Manual for PovMap, Development research Group, The World Bank, Washington, D.C.

ХАВСРАЛТ 1: МӨНГӨН ДҮНГЭЭР ХЭМЖИГДЭХ ЯДУУРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Элбэрс, Ланжоу (2003) нарын боловсруулсан аргачлалын үндсэн санаа тун энгийн. Эхлээд өрхийн амьжиргааны түвшний судалгаа болон хүн амын тооллогын аль алинд нь байгаа ижил үзүүлэлтээс сонгон аваад өрхийн амьжиргааны түвшний судалгааны мэдээн дээр үндэслэн нэг хүнд ногдох зардлын логарифмчлагдсан уттуудад регрессийн загвар байгуулан үнэлнэ. Дараа нь регрессийн параметруудийг ашиглан тооллогод хамрагдсан өрх бүрийн зардлыг таамаглах оролдлого хийнэ. Үүний дараа хүн амын аж байдлын хэд хэдэн үзүүлэлтүүдийг газар зүйн байршилаар тооцон гаргана.

“Хүн амын аж байдлын” гэж нэрлэж буй энэ үзүүлэлтэд өрхийн зарлага дээр үндэслэсэн багц үзүүлэлтүүдийг багтаана. Ядуурлын хамралтын хүрээ (P0)-г тооцох бөгөөд үүнээс гадна ядуурал болон орлогын тэгш бус байдлыг илэрхийлэх бусад үзүүлэлтүүдийг тооцон гаргах боломжтой (Аткинсоны тэгш бус байдлын хэмжүүр, ерөнхийлсөн Энтропи бүлгийн тэгш бус байдлын индекс, FGT ядуурлын хэмжүүр болон Жини коэффициент гэх мэт).

Энэ арга нь харьцангуй энгийн арга мэт боловч регрессийн загварт орон зайн автокорреляци (нэг нутаг дэвсгэрт оршин байгаа өрхүүдийн хэрэглээ өөр хоорондоо харилцан хамааралтай байх) болон гетероскедастик байж болох эсэхийг нягтлан засварлах үед нэлээд нарийвчилсан цогц тооцооллыг шаардана. Түүнчлэн аж байдлын олон үзүүлэлтийг эдгээрийн стандарт алдааны хамт тооцох шаардлага гардаг бөгөөд уг тооцооллыг хийхэд төвөгтэй, хялбар бус болгодог.

Ядуурлын зураглал хийх аргачлалыг доорхи гурван үе шатаар тайлбарлаж болох бөгөөд үе шат бүр нь зайлшгүй дамжих чухал алхмууд юм. Эдгээрийг дээр дурьдсан Элбэрс, Ланжоу (2002, 2003) нар болон Мистаен (2002) нарын онолын материалуудаас иш татлаа.

Эхний үе шат

Эхлээд өрхийн амьжиргааны түвшний судалгаа болон хүн амын тооллогоос харьцуулж болох шалгуурыг хангасан тодорхойлогч үзүүлэлтүүдийг сонгон авна. Бидний байгуулж буй ядуурлын зураглалыг үндэсний хэмжээнд тооцсон ядуурлын үзүүлэлтүүдтэй нийцтэй байлгахын тулд тооллого болон амьжиргааны түвшний судалгааны аль алинд нь байгаа, харьцуулж болохуүц үзүүлэлтүүдийг сонгож авах нь чухал. Ингэхдээ эхлээд тооллого, судалгаанд орсон эдгээр сонгогдсон үзүүлэлтүүдийг хэрхэн асуусан болон тэдгээрт өгсөн байж болох хариултыг нягтлан авч үзсэн. Сонгосон асуултуудаа ашиглан багц үзүүлэлтүүдийг гарган авна. Хэдийгээр бид үзүүлэлт тус бүрийн тархалт ижил эсэхийг харьцуулж болох боловч практикт зөвхөн тэдгээрийн дундаж утга ижил эсэхийг нягтлах замаар тухайн үзүүлэлтүүд ижил зүйлийг илэрхийлж байгаа эсэхийг шалгадаг. Дараагийн үе шатанд байгуулах загваруудынхаа таамаглах чадварыг нэмэгдүүлэх үүднээс эдгээр тооцоолол, дүн шинжилгээнүүдийг тооцооны түвшин буюу шатлал (strata) тус бүрээр хийнэ

Боломжит бүх үзүүлэлтүүдийн жагсаалт болон эдгээрийн дундаж ижил төстэй эсэхийг шалгасан шинжүүрийн үр дүнг хэрэв уншигч та харах хүсэлтэй бол судлаач нарт хандан авч үзэх боломжтой.

Хоёр дахь үе шат

Эхлээд өрхийн амьжиргааны түвшний судалгааны мэдээллийн баазыг ашиглан нэг хүнд ногдох өрхийн зардлыг загварчилсан. Тооцооллын нарийвчлалыг хангахын тулд загварчлалын тооцоог хот, хөдөөгөөр эхэлж тооцсон болно.

һ өрхийн зардлын түвшин (y_{ch})-гийн загварыг байгуулья гэж үзвэл x_{ch} нь тодорхойлогч хүчин зүйлсийн багц бөгөөд, харин u_{ch} нь үлдэгдэл хүчин зүйлийг илэрхийлнэ:

$$\ln y_{ch} = E[\ln y_{ch} | \mathbf{x}_{ch}] + u_{ch} \quad (1)$$

Нутаг дэвсгэрийн нэгж нь эхний үе шатанд түүврийн шатлалаар тодорхойлогоно. Энэ нь олонх тохиолдолд тооллогын нэгжийг илэрхийлдэг боловч заавал ийм байх албагүй. Тодорхойлогч хүчин зүйлсүүд нь тооллого болон өрхийн амьжиргааны түвшний судалгааны асуулгын аль алинд нь ижил орсон байх ёстой бөгөөд яг ижил тодорхойлогдсон байх ёстой. Мөн түүнчлэн эдгээр хүчин зүйлс нь хүн амын аж байдлын янз бүрийн үзүүлэлтийг бодитой хэмжин харуулахын тулд ойролцоо буюу ижил цаг хугацаанд цуглувлагдсан байх шаардлагатай. Бүх боломжит хүчин зүйлсийн жагсаалтыг эхний үе шатанд тодорхойлсон.

Хэрвээ дээрх тэгшитгэлийг шугаман тэгшитгэл болгоё гэвэл нэг өрхөд ногдох зардлын тэгшитгэлийг дараах байдлаар логарифмчилна.

$$\ln y_{ch} = \mathbf{x}_{ch}' \boldsymbol{\beta} + u_{ch} \quad (2)$$

Алдаа/үлдэгдэл хүчин зүйлсийн утгуудын вектор и нь $F(0, \Sigma)$ тархалттай байх бөгөөд энэхүү шугаман тэгшитгэл (2)-ийг Ерөнхийлсөн Хамгийн Бага Квадратын аргаар (GLS) үнэлнэ. Үүнийг үнэлэхдээ боломжит авто корреляци болон хетеросидастисити (ижил нэгжээс сонгогдсон өрхүүдийн зардал нь харилцан хамааралтай байх) –ийн чанарыг тооцоонд харгалзан үзэхийн тулд эн тэргүүнд алдааны вариац-ковариацын матриц Σ -уудыг үнэлэх хэрэгтэй болно. Ингэхдээ эхлээд алдааны утгыг дараах байдлаар тодорхойлно:

$$u_{ch} = \eta_c + \varepsilon_{ch} \quad (3)$$

η_c -нь байршлын нөлөөг, харин ε_{ch} -нь бие даасан алдааны утгуудыг тус тус илэрхийлнэ.

Практикт эхлээд тэгшитгэл (2) –ийг Энгийн Хамгийн Бага Квадратын (OLS) аргаар үнэлэх бөгөөд алдааны хэлбэлзлийг үлдэгдэл хүчин зүйлсийг ашиглан үнэлж \hat{u}_{ch} -аар илэрхийлнэ. Дараа нь үлдэгдэл хүчин зүйлсийг өөр хоорондоо хамааралгүй өрх болон байршлын бүрэлдэхүүн хэсэг болгон задална:

$$\hat{u}_{ch} = \hat{\eta}_c + e_{ch} \quad (4)$$

Байршлын хүчин зүйлийг ($\hat{\eta}_c$) нийт үлдэгдлийн (residuals) бүлгийн дунджаар үнэлэх тул өрхийн бүрэлдэхүүн хэсгийг (e_{ch}) хасаж тооцно. Ингээд (e_{ch}^2)-ийг загвар 2 дахь бүх үл хамаарах хүчин зүйлийн үзүүлэлтүүд, тэдгээрийг зэрэгт дэвшүүлсэн болон хоорондын уялдааны үзүүлэлтүүд, аж байдлын үзүүлэлтүүдийг регрессчлэх замаар гетероскедастик загварчилна. Энд ложистик загварыг ашигласан⁴.

Алдааны энэ хоёр тооцоог дараах хоёр матрицыг гаргахад ашигласан. Үүнд: $\hat{\Sigma}$ болон анхны загвар 2-ын үнэлэгдсэн вариац-ковариацын матриц болно. Сүүлийн матриц нь загвар 2-ын коэффицентүүдийг үнэлэх боломжийг өгнө.

⁴ Аргачлалын буюу загварчлалын онолын талаарх илүү нарийвчилсан мэдээллийг Mistiaen et al. (2002)-с үзнэ үү.

Гуравдугаар үе шат

Ядуурлын зураглалыг гүйцээхийн тулд бид хоёрдугаар үе шатанд тооцогдсон параметрүүдийг тооллогын өрх тус бүрт хамаатуулж нэг хүнд ногдох зардлыг логарифм хэлбэрээр таамаглан тооцох буюу тооцооны алдааг загварчилж тооцсон.

Аж байдлын индексүүдийн вариацын тооцоо нь маш нарийн төвөгтэй үйлдэл учир аж байдлын индексийн дисперсийг тооцохдоо дахин түүвэрлэх (bootstrapping) аргыг хэрэглэсэн. Өмнөх үе шатуудаас холбогдох үзүүлэлтүүдийн хэд хэдэн параметрүүд болон алдааны утгуудыг гаргаж авсан. Ингээд тооллогын бүх өрхөөр таамаглагдаж буй утга болон алдааны утга дээр үндэслэн өрхийн аж байдлын индексийг (\hat{y}_{ch}^r) дараах байдлаар тооцон гаргасан:

$$\hat{y}_{ch}^r = \exp(\mathbf{x}_{ch}' \tilde{\beta}^r + \tilde{\eta}_c^r + \tilde{\varepsilon}_{ch}^r) \quad (5)$$

Энэ үйлдлийг 100 дахин давтан хийсэн бөгөөд давтан хийх бүрт бүх коэффициентүүд болон харгалзах алдааны утга бүрийг тооцсон. Тооцон гаргасан өрхийн аж байдлын дундаж индекс нь бидний гол үзүүлэлт бөгөөд энэхүү индексийн стандарт хазайлт нь эдгээр тооцооны стандарт алдааг илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2: МЭДЭЭЛЛИЙН САН, МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтүүдээр тооцсон ядуурлын зураглалыг гаргахад тоо мэдээллийн олдоц тун чухал юм. Хамгийн чухал нь өрхийн зарлагын мэдээлэл агуулсан өрхийн судалгаа хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээлэл байх шаардлагатай. Үрьд нь ийм судалгаа, тооллого хийгдээгүй бол мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын дүр төрхийн судалгааг үндэслэн тооцохоос өөр аргагүй болно. Өрхийн түвшний аж байдлын индекс, ядуурлын шугамыг ядуурлын зураглалыг гаргахад ашиглана. Хүн амын амьжиргааны түвшний ялгааг газар зүйн байршил, түүх, яс үндэс, зах зээлийн боломж, нийтийн үйлчилгээ, дэд бүтэц, төрийн бодлогын хэрэгжилтийн байдлаар харахад өрхийн түвшний мэдээллээс гадна аймаг, сум, дүүргийн түвшний мэдээлэл ядуурлын газар зүйн зураглалыг гаргахад чухал хэрэгтэй байдаг.

Мөнгөн дүнгээр үл хэмжигдэх үзүүлэлтүүдийн газрын зураглалыг төвөггүйгээр Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээллээс хийх боломжтой байсан.

Тооллого

Манай Улс Хүн ам, орон сууцны тооллогоо хамгийн сүүлд 2010 онд хийсэн. Энэ тооллогын асуултгад нарийвчилсан олон асуултууд орсон хэдий ч өрхийн орлого, зарлагын талаар мэдээлэл байхгүй байсан. Хувь хүний түвшинд хүн ам зүй, боловсрол, эдийн засгийн үйл ажиллагааны талаар асуултууд орсон. Өрхийн түвшинд орон сууцны талаарх зарим асуулт орсон байв. Тооллогын мэдээллийн санд 2,647,685 хүн, 713,780 өрхөд тоологдсон байна. Тооллогын ажлыг нийт 10,959 тооллогын нэгжид явуулсан бөгөөд нэг тооллогын нэгжид дунджаар 65 өрх тоологдсон.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь өрхийн түвшний зарлагын мэдээллийг цуглуулдаг үндэсний хэмжээний судалгаа юм. Энэхүү судалгааг 2011 онд явуулсан учир тооллогын мэдээлэлтэй хослуулан ашиглахад цаг хугацааны хувьд маш тохиромжтой байсан. Мөн Хүн ам, орон сууцны тооллогын зарим асуултуудтай төстэй асуултууд судалгаанд олон байв.

Бидний регрессийн загварт ашигласан аж байдлын индекс нь (нэг хүнд ногдох зарлага) Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэлд үндэслэн тооцсон ядуурлын аж байдлын үзүүлэлтүүдтэй (YCX, 2012) адил байгаа. Ийнхүү өрхийн түвшний аж байдлын индекс, ядуурлын шугамыг ядуурлын дүр төрх болон ядуурлын газар зүйн зураглалд ашигласан нь эдгээр үр дүн хоорондоо хэрхэн тохирч байгааг харуулсан юм. Энэхүү байдал нь тооцооллыг засаг захиргааны анхан шатны нэгжид шалгах боломжийг олгосон.

Засаг захиргааны нэгж

Монгол Улсын засаг захиргааны нэгжийн бүтэц маш тодорхой бөгөөд ойлгомжтой. Засаг захиргааны нэгжид 21 аймаг, нийслэл хот орж байгаа бөгөөд эдгээр нь таван бүст хуваагдана. Засаг захиргааны анхан шатны нэгжийг 329 сум, нийслэл хотын есөн дүүрэг бүрдүүлж байгаа бөгөөд сумдыг багууд, нийслэлийн дүүргүүдийг хороод бүрдүүлж байна. Хүснэгт 2-т эдгээр засаг захиргааны нэгжүүдийн талаарх зарим мэдээллийг үзүүлэв. Аймгууд өөр хоорондоо хүн амынхаа тоогоор ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, 2010 оны байдлаар Говьсүмбэр аймагт 12576 хүн амьдарч байхад нийслэл хотод ойролцоогоор 1115000 хүн амьдарч байх жишээтэй.

Өмнө дурьдсанаар, мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлын үзүүлэлтийг үнэнд ойрхон / статистикийн магадлал өндөр/ тооцохын тулд засаг захиргааны нэг нэгжид ногдох өрхийн хамгийн бага тоог тогтоох нь зүйтэй байсан. Хамгийн цөөн өрхтэй аймгууд ч гэсэн өрхийн тооны энэ хязраарлалтыг хангаж байна. Харин олон сумын өрхийн тоо дээр дурьдсан доод хязгаарт хүрэхгүй байгаа учир ядуурлын үзүүлэлтийг сумын түвшинд статистикийн өндөр магадлалтай тооцоход хүндрэлтэй байв. Иймд бид зарим хөрш залгаа сумдыг багцалж тооцоонд оруулсан. Сумдыг нэгтгэн багцлах гол шалгуур нөхцөл нь хил залгаа “төстэй” байх явдал байсан. Ядуурлын үзүүлэлтүүдийг зарим сумдаар багцалж тооцсоны дараа гарсан үзүүлэлтийг сум бүрт салгаж харуулсан. Үүний гол зорилго нь ядуурлын үзүүлэлтийг статистикийн өндөр магадлалтайгаар сум бүрээр тооцоход оршиж байгаа юм.

Хүснэгт 2: Монгол Улсын засаг захиргааны нэгжийн талаарх мэдээлэл

Засаг захиргааны нэгж	Нэгжийн тоо	Өрхийн тоо			Хүний тоо		
		Голч	Хамгийн бага	Хамгийн өндөр	Голч	Хамгийн бага	Хамгийн өндөр
Бүс	5	121,975	52,171	302,118	413,026	179,587	1,114,507
Аймаг/Нийлэл	22	19,045	3,841	302,118	72,465	12,576	1,114,507
Сум/Дүүрэг	338	736	226	73,352	2,537	687	265,518

Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээллийг үндэслэн судлаачдын хийсэн тооцоо
